



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/60

Бор-Өндөр

**Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.3, 40.4, 40.6, 40.9, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн A/127 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлэх зорилготой хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:

Засаг даргын орлогч

Хорооны нарийн бичгийн дарга: Хүүхэд, Гэр бүлийн Нийгмийн ажилтан

Гишүүд:

Бор-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Бор-Өндөр сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын дарга

Бор-Өндөр сум дахь Сум дундын Прокурорын газрын ерөнхий прокурор

Бор-Өндөр сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга

Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургуулийн захирал

Ерөнхий боловсролын Оюуны уурхай сургуулийн захирал

Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 419
дүгээр ангийн харъяа Бор-Өндөр сум дахь 138 дугаар
тойргийн Шийдвэр гүйцэтгэгч

Хүүхэд, Гэр бүлийн Нийгмийн ажилтан

Хүүхдийн элч

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд хагас, бүтэн жил тутамд ажлаа тайлагнахыг хорооны дарга, Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/21 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ